



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 30

Мандалговь

┌ Сонгон шалгаруулалт зохион байгуулах
комисс томилох тухай ┐

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3.2, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, “Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 141 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Түвшинбаяр (Салбар зөвлөлийн гишүүн)
Гишүүд: А.Лхагвасүрэн (Салбар зөвлөлийн гишүүн)
Т.Баярсайхан (Салбар зөвлөлийн гишүүн)
Н.Мөнгөн (Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээллийн технологийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: С.Цэнгэлмаа (Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Хоёр. “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасан сонгон шалгаруулах комиссын чиг үүргийг хэрэгжүүлэн, шалгалтын бэлтгэлийг ханган, зохион байгуулж холбогдох мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг комисс (Б.Түвшинбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН